

**НИЙСЛЭЛИЙН ТӨР ЗАХИРГААНЫ АВТО БААЗ УТУГ-ЫН
2025 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН
ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ**

2025 оны 11 дүгээр сарын 27

Улаанбаатар хот

№	Д/д	Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, тогтоомж	Төсөв (сая. төгрөг)	Шалгуур үзүүлэлт	Суурь төвшин	Зорилтот төвшин	Хүрсэн түвшин буюу хэрэгжилт (хүрээгүй бол тайлбар)	Хэрэгжилтийн хувь
Стратеги төлөвлөгөөний зорилго: Төрийн үйлчилгээнд стандарт соёлыг дээшлүүлж, чанартай шуурхай үйлчилгээг хүргэж ажиллах. НТЗАБ-ын СТ-6								
1	Зорилт: Нэг. Төрийн үйлчилгээг мэргэшсэн, ёс зүй, сахилга баттай албан хаагчдаар бүрдүүлэх, нийгмийн баталгааг хангах НТЗАБ УТУГ-ын СТ-6.1							
	1.1	Байгууллагын 2024-2028 оны стратеги төлөвлөгөөг боловсруулж батлуулна.	-	Үйл ажиллагааны хэрэгжилтийн хувиар	0	100%	Нийслэлийн Засаг даргын Тамгын газраас Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын засаглалын төлөв байдлын үнэлгээ хийсэн. Уг үнэлгээний зөвлөмжийн дагуу 2025 оны 07 дугаар сард байгууллагын 2024-2028 оны стратеги төлөвлөгөөг боловсруулж батлуулсан.	100%
	1.2	Жолооч мэргэжлийн чадварыг дээшлүүлнэ.	нарын ур	Мэргэшсэн жолоочийн тоо	48	56	Үйлчилгээний жолооч П.Баярмандах №0093146, Д.Батболд №0095925, А.Бодьярагчаа №0096055, Л.Ганболд №0016695, Б.Ганбаяр №0026487, Д.Ганзориг №0096142, Ж.Мөнхтөр №0092228, Т.Нэргүй №0095587, Б.Нямсамбуу №0095679, Д.Одгэрэл №0095534, Х.Отгонбаяр №0095888, Д.Сайнбаяр №0093437, Д.Эрдэнэбаяр №0087202, Д.Эрдэнэ-Очир №0095708 нийт 14 Үйлчилгээний жолооч шинээр мэргэшсэн үнэмлэх авсан. Мөн	100%

							Үйлчилгээний жолооч Б.Сүхбаатар, Б.Нацагдорж, Э.Гэндэндорж, Б.Галаа, Э.Энх-Амар, Э.Энхзаяа нарын 6 Үйлчилгээний жолооч "В" ангиллын мэргэшсэн зэргийн үнэмлэхийн хугацаа дууссан байсныг сунгуулсан. 2025 оны байдлаар мэргэшсэн зэрэгтэй 6 үйлчилгээний жолооч ажлаас чөлөөлөгдсөнөөр байгууллагын нийт 78 үйлчилгээний жолоочийн 72% буюу 56 нь мэргэшсэн жолооч болсон байна.	
1.3	Албан нийгмийн хангана.	хаагчдын баталгааг	20 (сая.төг) Өөрийн хөрөнгөөр	Үйл ажиллагааны хэрэгжилтийн хувиар	96%	100%	Үйлчилгээний жолооч Ч.Гантөмөрийн төрсөн эцэг нас барсан тул Б/22 дугаар тушаалаар 1.5 сая, Манаач Н.Нямаагийн төрсөн эх нас барсан тул Б/23 дугаар тушаалаар 1.5 сая, Диспетчер-механик Ч.Нарантуяагийн төрсөн эцэг нас барсан тул Б/26 дугаар тушаалаар 1.0 сая, Үйлчилгээний жолооч А.Баттулгын төрсөн дүү нас барсан тул Б/39 дугаар тушаалаар 0.5 сая, Үйлчилгээний жолооч С.Баатарсүхийн төрсөн эцэг нас барсан тул Б/45 дугаар тушаалаар 1.0 сая, Ашиглалтын инженер Ц.Оюунцэцэгийн төрсөн ах нас барсан тул Б/54 дугаар тушаалаар 0.5 сая, Ерөнхий инженер Ч.Энхсайханы төрсөн ах нас барсан тул Б/38 дугаар тушаалаар 0.5 сая, Захиргаа, хүний нөөцийн хэлтсийн дарга М.Болормаа нь эмчилгээ хийлгэх шаардлагатай болсон тул Б/55 дугаар тушаалаар 1.5 сая, Ахмад настан Б.Намсрай нас барсан тул ар гэрт нь мөнгөн тусламж үзүүлж Б/65 дугаар тушаалаар 0.5 сая, Үйлчилгээний жолооч Б.Ариунболд нь зүрхэнд гуурс суулгах мэс засалд орсон тул Б/76	100%

							дугаар тушаалаар 0.5 сая, Манаач Ж.Санжаагийн эхнэр нас барсан тул Б/79 дүгээр тушаалаар 0.5 сая, Үйлчилгээний жолооч Б.Ариунболд нь нас барсан тул ар гэрт нь мөнгөн тусламж олгох тухай Б/83 дугаар тушаалаар 3.5 сая, Манаач Н.Буяннэмэхийн эхнэр нас барсан тул Б/114 дүгээр тушаалаар 1.0 сая төгрөг нийт 13 албан хаагчдад нийт 14.5 сая төгрөгийн нэг удаагийн буцалтгүй тусламж, тэтгэмж олгосон. Ажилтан, албан хаагчдын эрүүл мэндийн үзлэгт 7.0 сая төгрөг, ахмад настнуудад хүндэтгэл үзүүлэх тухай А/09 дүгээр тушаалаар 34 ахмадад 5.1 сая төгрөгийн төсөв гарган хүндэтгэл үзүүлсэн. 2025 онд ажилтан, албан хаагчдын нийгмийн баталгааг хангах ажлын хүрээнд нийт 26.6 сая төгрөгийг зарцуулан ажилласан байна. Мөн Үйлчилгээний жолооч А.Баярсүх, Б.Нацагдорж Г.Ууганбаяр, Э.Мөнхдалай, Н.Дагвасүмбэрэл нар НЗДТГ-аас хэрэгжүүлж буй "Албан тушаалын орон сууц"-ны хөтөлбөрт, Үйлчилгээний жолооч М.Батбилэг, Д.Мөнхбат, Н.Ширнэндорж, Г.Рэнцэндорж, Н.Энхээбаатар нар нь НОСК-ийн "Түрээслээд өмчлөх орон сууц"-ны зээлд тус тус хамруулан ажилласан байна.	
Хсёр. Бодлогын баримт бичгийн хүрээнд: НЗДҮАХ- 4.1.4, 5.1.14, 5.1.15, 5.2.9, НХТЖҮЧ-4.1.5, 5.5.2, 6.2.9								
2	2.1	Төрийн худалдан авах ажиллагаагаар дамжуулан дотоодод үйлдвэрлэсэн бүтээгдэхүүний	7.5 (сая.төг) Өөрийн хөрөнгөөр	Дотоодын аж ахуйн нэгж, байгууллага, хувь хүнээс	2	3	Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн хуульд заасны дагуу "хөдөлмөрийн аюултай, хортой нөхцөлд ажил үүрэг гүйцэтгэдэг ажилтныг хор саармагжуулах бодис, хүнсний	100%

	худалдан авалтыг дэмжсэн байна.		худалдан авалт хийх			бүтээгдэхүүн, хоолоор хангах, хор саармагжуулах сүү сүүн бүтээгдэхүүнийг "СҮҮ" ХХК-с 0.8 сая, "Үсэг хоршоо" ХХК-с ажлын үнэмлэх хэвлүүлэхэд 0.7 сая, Үндэсний шуудан холбооны Монголын цахилгаан холбоо ТӨК, үндэсний үүрэн холбооны оператор "Юнивишн" ХХК, Мобиком ХХК-ын интернэтийн үйлчилгээнд 2025 оны 11 дүгээр сарын 28-ны өдрийн байдлаар 6 сая нийт 7.5 сая төгрөгийн зардлуудыг тус тус зарцуулан ажиллаж байна.	
2.2	Төсвийн ерөнхийлөн захирагчийн эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын "Шилэн дансны тухай хууль"-ийн хэрэгжилтэд хяналт тавьж төсөв, санхүүгийн ил тод байдлыг хангуулна.	-	Санхүүгийн ил тод байдлыг ханган ажиллах.	100%	100%	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгийг үр ашигтай захиран зарцуулах, санхүүгийн ил тод байдлыг хангах зорилгоор Шилэн дансны тухай хуулийг хэрэгжүүлж, заасан хугацаанд тайлагнан ажиллаж байна. 2025 оны 11 дүгээр сарын 28-ны өдрийн байдлаар нийт 151 мэдээ, мэдээллийг шилэн дансанд бүрэн байршуулсан.	100%
2.3	Төрийн байгууллага, албан тушаалтныг авлигын эрсдэлээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг үе шаттай зохион байгуулж, төрийн байгууллагын үйл ажиллагааны ил тод, нээлттэй байдлыг хангана.	-	Үйл ажиллагааны хэрэгжилтийн хувиар	100%	100%	2025 оны 02 дугаар сарын 15-ны өдөр Газрын дарга Э.Болор-Эрдэнэ болон 3 хэлтсийн дарга ХАСХОМ-ыг хуулийн хугацаанд мэдүүлсэн бөгөөд Авлигатай тэмцэх газар, Ёс зүйн хороотой хамтран зохион байгуулсан "Төрийн албан хаагчийн ёс зүй", "Авлига ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх нь" сэдэвт сургалтад хамрагдсан байна. Авто баазын үйл ажиллагааны ил тод, нээлттэй байдлыг ханган байгууллагын baaz.ub.gov.mn пэйж хуудас болон фэйсбүүк цахим сүлжээнд мэдээ.	100%

						мэдээллийг цаг алдалгүй нийтэлж, олон нийтэд хүргэн ажиллаж байна.	
2.4	"Тэрбум мод" үндэсний хөдөлгөөний хүрээнд мод тарих, нөхөн сэргээх.	-	Тарьсан, арчилсан модны тоо	100	100	"Тэрбум мод" үндэсний хөдөлгөөний хүрээнд ногоон байгууламжийг нэмэгдүүлэх, арчлалт хамгаалалтыг сайжруулах чиглэлээр зохион байгуулж буй "Ногоон хот – Иргэний оролцоо" мод тарих аянд нэгдэж хамт олноороо 2025 оны 05 дугаар сарын 10-ний өдөр Хан-Уул дүүргийн 14 дүгээр хороо, Айцын аманд тарьсан 120 модоо арчилж, тордсон. Мөн 2025 оны 10 дугаар сарын 11-ний Бямба гарагт шинээр 44 модны суулгац суулгаж, өмнөх жилүүдэд тарьсан 120 модны арчилгаа, усалгаа хийсэн.	100%
2.5	Байгууллагын архивд хадгалагдаж буй цаасан суурьтай баримтыг цахим хэлбэрт шилжүүлнэ.	-	Үйл ажиллагааны хэрэгжилтийн хувиар	100%	100%	Цахим нөхөн бүрдүүлэлтийг https://arch.ulaanbaatar.mn/ системд 2024 онд үүссэн үндсэн үйл ажиллагааны чиглэлээр гаргасан 49, боловсон хүчний чиглэлээр гаргасан 141 захирамжлалын баримтын агуулга тодорхойлон программд оруулсан. Нийслэлийн Архивын газраас гаргасан хуваарийн дагуу 190 захирамжлалын баримтад батлан шалгалт хийж, Нийслэлийн архивын газрын Төрийн архивын хэлтсийн зааварлагч-арга зүйч Э.Наранцацралд актаар цахим баримтыг хүлээлгэн өгсөн.	100%

Гурав. Хуулиар олгосон нийтлэг чиг үүргийг хэрэгжүүлэх хүрээнд: ГХЗУСТХ- 28, ЖЭТБХТХ- 19.1.6, ХАБЭАТХ- 14.1, 15.1,

3	3.1	Хүчин төгөлдөр мөрдөгдөж буй хууль тогтоомжийн дагуу байгууллагын үйл ажиллагааг хэвийн явуулна.	-	Үйл ажиллагааны хэрэгжилтийн хувиар	100%	100%	Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, Төсвийн тухай хууль, Иргэний хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Төрийн албаны тухай хууль, Төрийн хэмнэлтийн тухай хууль, Даатгалын тухай хууль, Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хууль, Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хууль, Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль, Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль болон Засгийн газрын 2018 оны 239 дүгээр тогтоолоор батлагдсан Замын хөдөлгөөний дүрэм, 2024 оны 238 дүгээр тогтоолоор батлагдсан "Төрийн үйлчилгээний албан тушаалын зэрэглэл, албан тушаалын жагсаалтыг шинэчлэн тогтоох тухай" тогтоол, 2024 оны 128 дугаар тогтоолоор батлагдсан "Төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоох тухай" тогтоол, Сангийн сайдын 2022 оны "Зардлын норматив батлах тухай" 279 дүгээр тушаал, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2014 оны 66 дугаар тогтоол "Нийслэлийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн хөдөлгөөн, түүнтэй холбогдох бусад харилцаа", Нийслэлийн засаг даргын "Замын хөдөлгөөний ачааллыг буруулах" 2020 оны 1037 дугаар	100%
---	-----	--	---	-------------------------------------	------	------	--	------

						захирамж, "Хуулийн хэрэгжилтийг хангах захирамж арга хэмжээний тухай" 2022 оны 789 захирамж, "Тариф шинэчлэн батлах тухай" 2024 оны А/56 дугаар захирамж, Нийслэлийн Засаг даргын 2025 оны А/615 дугаар захирамжийг байгууллагын өдөр тутмын үйл ажиллагаанд удирдлага болгон ажиллаж байна.	
3.2	Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 28 дугаар зүйлд заасан гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиг үүргийг хэрэгжүүлэн ажиллана.	-	Үйл ажиллагааны хэрэгжилтийн хувиар	100%	100%	2025 оны Авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөө батлагдсантай холбогдуулан Эрх зүйн асуудал хариуцсан ажилтан А.Гантөгс байгууллагын хэмжээнд Эрүүгийн хуулийн тусгай ангийн 22-р бүлэгт заасан авлига албан тушаалын гэмт хэргээс урьдчилан сэргийлэх мэдээллийг албан хаагчдад хүргэсэн. Мөн Цахим гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай, Замын хөдөлгөөний зөрчлийн тухай, Залилах гэмт хэргийн тухай мэдээллүүдийг албан хаагчдад хүргэн ажилласан. Үйлчилгээний жолооч нарт Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль, Замын хөдөлгөөний дүрмийг баримтлан зөрчлөөс урьдчилан сэргийлэх талаар мэдээлэл, сануулга тогтмол хүргэн ажиллаж байна.	100%
3.3	Жендерийн эрх тэгш байдлыг хангах тухай хууль, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн хэрэгжилт ханган ажиллана.	-	Үйл ажиллагааны хэрэгжилтийн хувиар	100%	100%	Байгууллагын хэмжээнд Жендерийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1.6 дахь заалтыг үндэслэн "Жендерийн тэгш байдлыг хангахад төрийн албан хаагчийн оролцоо" уриатайгаар мэдээлэл, танилцуулга хийж, албан хаагчдад хүргэсэн.	100%

						Мөн байгууллагын олон нийтийн цахим сүлжээ болон Ulaanbaatar Erg системээр "Жендерт суурилсан хүчирхийлэлтэй тэмцэх аян", "Соёл түгээ", "Харилцан хүндэтгээ" зэрэг аянуудад нэгдэн танилцуулга хуудас бэлдэж, олон нийтэд хүргэсэн. Жендерийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийн хэрэгжилтийг ханган байгууллагад ажиллагсдын хүйсийн тэнцвэрт байдлын тайланг Нийслэлийн Засаг даргын Тамгын газарт хүргүүлсэн. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн 27 дугаар зүйлд заасныг үндэслэн байгууллагын Хөдөлмөрийн аюулгүй байдлын тухай журам, 2025 оны төлөвлөгөөг баталж, хэрэгжүүлэн ажиллаж байна.	
3.4	ХАБЗА-н тухай хуулийн хэрэгжилтийг ханган арга хэмжээнүүдийг зохион байгуулж ажиллана.	-	Зохион байгуулах арга хэмжээний хувиар	100%	100%	Байгууллагын 2025 оны Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн төлөвлөгөөнд тусгасны дагуу өдөр тутмын болон хэд хэдэн томоохон арга хэмжээ зохион байгуулж ажилласан. Үүнд: -ХАБЗА-н тухай хуулийн 14.1 зүйл заалтыг үндэслэн НЗД-н шуурхай хурлаар өгсөн үүрэг чиглэлийн дагуу СБД-ийн эрүүл мэндийн төвтэй хамтран ажиллах гэрээ байгуулж, 2025 оны 05 дугаар сарын 19-ний өдрөөс 06 дугаар сарын 03-ны өдрийг хүртэл хугацаанд албан хаагчдыг эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулсан. -Ажилтан, албан хаагчдын амьдралын зөв хэвшил, эрүүл ахуйг дэмжих 2025 оны 10 дугаар сарын 25-ны өдөр байгууллагын аварга шалгаруулах 5	100%

						төрөлт спортын тэмцээнийг амжилттай зохион байгуулсан. -Байгалийн эрсдэл болон гамшгийн үеийн урьдчилан сэргийлэх сургалт судалгааг сар бүрийн сүүлийн пүрвэ гаригт ажилтан, албан хаагчдыг хяналтын судалгаанд хамруулан ажиллаж байна. -Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн 15.1 зүйл заалтын дагуу Механик засварчин, манаач, сантехникч нарт ажлын онцлогт тохирсон хувцас хамгаалах хэрэгслийн судалгааг гарган худалдан авалт хийсэн. -Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн талаар хууль тогтоомж дүрэм, журам, MNS 4969:2000 стандартын хэрэгжилтийг хангах чиглэлээр ажилтан, албан хаагчдад өдөр тутамд давтан зааварчилгаа өгч, хэрэгжилтэд хяналт тавин баталгаажуулан ажилладаг. -Паркуудын эмийн сангийн баяжуулалт хийж нэр төрөл олшруулан диспетчерүүдэд хариуцуулан өгч шаардлагатай үед ажилчдад түргэн тусламж үзүүлж хянаж байна. -Байгууллагын галын аюулгүй байдлыг хангуулж галын хорны хугацааг шалтан сар бүр тэмдэглэл хөтөлж хугацаа дууссан галын хорыг цэнэглүүлэхээр судалгааг гаргасан. -Тээврийн хэрэгслийн аюулгүй байдлыг хангахаар 56 тээврийн хэрэгслийн дугуйг сольж, 43 тээврийн хэрэгслийг ТУ-1 засвар үйлчилгээнд оруулсан.	
--	--	--	--	--	--	---	--

3.5	"Монгол бичгээр үйлдэх баримт бичгийн хэвлэмэл хуудас түүний бүрдэлд тавих үндсэн шаардлага" MNS6395:2022 стандартын дагуу хэвлэмэл хуудсыг захиалах, албан хэргийг крилл болон үндэсний хос бичгээр хөтөлж хэвшинэ.	0.5 (сая.төг) Өөрийн хөрөнгөөр	Үйл ажиллагааны хэрэгжилтийн хувиар	0	100%	Төрийн албан хэргийг 2025.01.01-ний өдрөөс хос бичгээр хөтлөх болсонтой холбогдуулан монгол бичгийн MNS6395:2022 стандартын шаардлагад нийцсэн хэвлэмэл хуудсыг 2025.01.06-ны өдөр Нийслэлийн архивын газрын дэргэдэх хэвлэлийн цехэд захиалж, захиалгын төлбөрт 0.3 сая төгрөгийн төлбөр, Монгол бичгийн алдаа шалгагч программын лицензийн хураамж 0.1 сая, сургалтын төлбөрт 0.1 сая, нийт 0.5 сая төгрөгийн зардлыг зарцуулсан. Мэдээлэл технологи, архив, бичиг хэргийн ажилтан Захиргааны албан хаагчдад 09 дүгээр сарын 08-ны өдөр Монгол бичгээр захирамжлалын баримт бичиг боловсруулах талаар сургалт зохион байгуулсан. 12 дугаар сарын байдлаар байгууллагын үндсэн үйл ажиллагааны болон хүний нөөцийн чиглэлээр гарсан А 29, Б 146 нийт 175 тушаалыг крилл болон Монгол бичгээр хөтөлсөн байна.	100%
	Нийслэлийн Засаг даргын 2025 оны А/01 дүгээр захирамж, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр, Нийслэлийн хөгжлийн 2025 оны төлөвлөгөөний	-	Үйл ажиллагааны хэрэгжилтийн хувиар	0	100%	Нийслэлийн Засаг даргын 2025 оны А/01 дүгээр захирамж, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр, Нийслэлийн хөгжлийн 2025 оны төлөвлөгөөний үндсэн чиглэлийг хөгжүүлэх зорилгын дагуу 2025 оныг бүтээн байгуулалтын жил болгон зарласантай холбогдуулан байгууллагын төв байрны дотор, гадна талын зам талбайг зүлэгжүүлж, мод тарих ногоон байгууламжийг нэмэгдүүлэх ажлыг зохион байгуулан ажиллаж байна.	100%

	үндсэн чиглэлийг хөгжүүлэх зорилгын дагуу нийгмийн тодорхой хэсгийг хамруулан шинэлэг шийдэл, инновац технологи шингээсэн, стандартад нийцсэн тохижилтын ажил зохион байгуулна.						
3.7	"Аалигатай тэмцэх үндэсний хөтөлбөр 2024-2030 он" хүрээнд үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулж, хэрэгжилтийг ханган ажиллана.	-	Үйл ажиллагааны хэрэгжилтийн хувиар	0	100%	2025 онд хэрэгжүүлэх Авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулан баталсан. Төлөвлөгөөний дагуу байгууллагын олон нийтийн цахим сүлжээ болон Ulaanbaatar Egr системээр авлигын эсрэг мэдээ мэдээлэл, танилцуулга байршуулан албан хаагчдад сурталчилж байгаа бөгөөд байгууллагын 1 давхарт байрлах мэдээллийн самбарыг Авлигын эсрэг үйл ажиллагааг мэдээлэн сурталчлах "Шударга ёс, хөгжил дэвшилд 110" мэдээллийн самбар болгон ажиллуулж тухай бүр мэдээллийг шинэчлэн ажиллаж байна. Байгууллагын үндсэн үйл ажиллагааны болон хүний нөөцийн чиглэлээр гарч буй тушаалын төслийн саналын хуудсанд ашиг сонирхлын зөрчилтэй эсэх талаар тайлбар аван баталгаажуулдаг болсон. Мөн байгууллагын үндсэн болон цаг үеийн үйл ажиллагаатай холбоотой хуулийн этгээдүүдтэй байгуулах гэрээ хэлэлцээр бүрт авлигаас урьдчилан сэргийлэх заалтыг тусган ажиллаж байна.	100%

	3.8	"Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үндэсний хөтөлбөр 2024-2030 он" хүрээнд үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулж, хэрэгжилтийг ханган ажиллана.	-	Үйл ажиллагааны хэрэгжилтийн хувиар	0	100%	Төрийн албаны ёс зүйн зарчим, хэм хэмжээ, шаардлагыг товч, тодорхой, ойлгомжтой хэлбэрээр ангилан төрөлжүүлэх, ёс зүйн тайлбар, гарын авлага, зөвлөмж, заавар боловсруулах ажлыг байгууллагын "Ёс зүйн зөвлөл"-д даалган хэрэгжүүлэхээр төлөвлөсөн. Байгууллагын "Ёс зүйн зөвлөл"-д хараат бус, бие даасан байдлыг хангах нөхцөлийг бүрдүүлж, шударга ёсны зарчмыг хэрэгжүүлэх талаар чиглэл өгсөн. Байгууллагын удирдлага нь төрийн албан хаагчийн ёс зүйн хууль тогтоомжийг мөрдүүлэх, хэвшүүлэх, баримтлан ажиллахад чиглэсэн үйл ажиллагааг "Ёс зүйн зөвлөл"-тэй хамтран хэрэгжүүлж байна. Иргэн, албан хаагчаас төрийн албан хаагчийн ёс зүйн асуудлаар 11-11 төвд 1 гомдол, 18001200 операторын дугаарт 1 гомдол ирснийг хянан шийдвэрлэж, ёс зүйн зөрчил гаргасан албан хаагчдад хариуцлага тооцон ажилласан. Албан хаагчийн ажлын гүйцэтгэлийг үнэлэх, албан тушаалд дэвшүүлэх, шагнах, урамшуулах, сургалтад хамруулах асуудлыг шийдвэрлэхэд төрийн албан хаагчийн ёс зүйн хууль тогтоомжид заасан шударга байх зарчим, шаардлагыг мөрдөх, шударга ажилласан байдал, ёс зүйн хариуцлага хүлээсэн эсэхийг харгалзан үзэж асуудлыг шийдвэрлэж байна.	100%
Дөрөв. Дүрмээр хүлээсэн чиг үүргийг хэрэгжүүлэх хүрээнд, НЗД-ын 2021 оны А/995 дугаар захирамж								

4	4.1	Нийслэлийн Төр захиргааны авто бааз УТҮГ-ын дүрмийн 4.1, Нийслэлийн Засаг даргын захирамжаар батлагдсан автомашин хэрэглэх эрх бүхий албан тушаалтан, байгууллагатай хууль тогтоомжийн хүрээнд ажил үйлчилгээний гэрээ байгуулан, байгууллагуудад автомашинаар үйлчилнэ.	-	Парк ашиглалтын хувиар	2024 парк ашиглалтын дундаж коэффициент 85%	87%	Нийслэлийн нутгийн захиргааны 44 байгууллагын 72 хэрэглэгчдэд "Дуудлагын автомашинаар үйлчлэх гэрээ" байгуулан тээврийн хэрэгслийн үйлчилгээ үзүүлэн ажиллаж байна. Мөн Ulaanbaatar Epr системийн дэд систем "Дуудлагын автомашины захиалгын систем"-ээр 2025 оны 11 дүгээр сарын 30-ны өдрийн байдлаар нийт 1036 удаагийн захиалга, дуудлага хүлээн авч төрийн тээврийн үйлчилгээ үзүүлсэн. Нийслэлийн Засаг даргын 2025 оны "Замын хөдөлгөөний түгжрэл, ачааллыг бууруулах талаар авах зарим арга хэмжээний тухай" А/248 дугаар захирамжаар 2025 оны "Цагаан сар"-ын баяртай холбогдуулан замын хөдөлгөөний түгжрэл, ачааллыг бууруулах зорилгоор 2025 оны 02 дугаар сарын 22-ны өдрөөс 2025 оны 02 дугаар сарын 27-ны өдрийг дуустал автомашины улсын дугаарын сүүлчийн орон нь тэгш, сондгойгоор 08:00-20:00 цагийн хооронд замын хөдөлгөөнд оролцуулах зохион байгуулалтын арга хэмжээ авах, А/1176 дугаар захирамжуудын дагуу 2025 оны 08 дугаар сарын 28, 30, 09 дүгээр сарын 02, 04, 06, 08, 10, 12, 14, 16-ны өдрүүдэд, сүүлчийн орон нь сондгой тоо (1, 3, 5, 7, 9)-оор төгссөн автомашиныг 2025 оны 08 дугаар сарын 27, 29, 31, 09 дүгээр сарын 03, 05, 07, 09, 11, 13, 15-ны өдрүүдэд, 08:00-20:00 цагийн хооронд бүсчлэлгүйгээр тус тус замын хөдөлгөөнд оролцуулах зохион	80%
---	-----	--	---	------------------------	---	-----	---	-----

						байгуулалтын арга хэмжээ авах заалтуудыг мөрдөн ажилласнаар 2025 оны байгууллагын ПАК үзүүлэлт 80.3% болон буурсан үзүүлэлтэй байна.	
4.2	Нийслэлийн Төр захиргааны авто бааз УТҮГ-ын дүрмийн 4.2. Үйлчилгээнд явж байгаа авто тээврийн хэрэгслийн аюулгүй байдал, стандарт, норм, нормативыг мөрдөж, шуурхай чирэгдэлгүй үйлчилнэ.	-	Хэрэглэгчийн зүгээс гомдолгүй байх.	Тээврийн хэрэгслийн аюулгүй байдал, жолооч нарын үйлчилгээний соёлыг сайжруулсан. 100%	100%	Нийслэлийн Төр захиргааны авто бааз УТҮГ-ын үйлчилгээнд явж байгаа тээврийн хэрэгслүүдийн аюулгүй байдал, стандарт, норм, нормативыг мөрдөж, шуурхай чирэгдэлгүй үйлчлэх ажлын хүрээнд Тоёота камри, Тоёота сиенна, Ланд крузер 300, Тоёота хайс зэрэг нийт 47 тээврийн хэрэгслээр парк шинэчлэлт хийсэн бөгөөд байгууллагын бүртгэлд байсан насжилт өндөртэй, цаашид төрийн тээврийн үйлчилгээнд ашиглах шаардлага хангахгүй 34 тээврийн хэрэгслийг Нийслэлийн Өмчийн харилцааны газарт шилжүүлсэн. Байгууллагын нийт тээврийн хэрэгслийн бүрэн, аюулгүй байдалд тогтмол төлөвлөгөөний дагуу хяналт, шалгалт хийдэг бөгөөд 2012-2015 оны насжилт өндөртэй 20 тээврийн хэрэгслүүдэд ТҮ-1, ТҮ-2 засвар үйлчилгээг графикийн дагуу хийж байна. 2025 онд нийт 44 байгууллагын 72 хэрэглэгчдэд гэрээний дагуу тогтмол, 14 байгууллагын 20 хэрэглэгчдэд Дуудлагын автомашины захиалгын системээр дуудлагын дагуу гомдол, чирэгдэлгүй тээврийн хэрэгслийн үйлчилгээ үзүүлэн ажилласан.	100%
4.3	Нийслэлийн Төр захиргааны авто бааз УТҮГ-ын дүрмийн 4.3. Монгол Улсын Нягтлан бодох	6,541.2 (сая.төг) Нийслэлийн төсөв	Төсөв санхүүгийн үйл ажиллагааг төлөвлөх,	100%	100%	Байгууллагын 2025 оны батлагдсан төсвийг хуваарийн дагуу 11 дүгээр сарын байдлаар 4,651.1 сая төгрөгийн төсвийн санхүүжилтийг авч ажилласан. Нягтлан бодох бүртгэлийн хуульд заасны дагуу	100%

	бүртгэлийн хуульд заасны дагуу байгууллагын батлагдсан төсвийг зориулалтын дагуу үр өгөөжтэй, хэмнэлттэй зарцуулж санхүүгийн анхан шатны бүртгэлийг хөтөлж, тайлан балансыг зохих хугацаанд гаргана.		хэрэгжүүлэх, хэмнэлттэй зарцуулах, өглөг авлагагүй ажиллах.			батлагдсан төсвийг зориулалтын дагуу үр өгөөжтэй, хэмнэлттэй зарцуулж, санхүүгийн анхан шатны бүртгэлийг хөтөлж, тайлан балансыг зохих хугацаанд гарган холбогдох газруудад хуулийн дагуу тайлагнан ажиллаж байна. 2025 оны төсөв санхүүгийн үйл ажиллагааг төлөвлөн 11 дүгээр сарын байдлаар нийт төлөвлөгөөний гүйцэтгэл 97%-ийн биелэлттэй байгаа бөгөөд төлөвлөгөөний дагуу 12 дугаар сард 100% болгон ажиллана.	
4.4	Нийслэлийн Төр захиргааны авто баяз УТҮГ-ын дүрмийн 4.4. Байгууллагын инженер, техникийн ажилтнуудыг мэргэжлийн өндөр боловсролтой, дадлага туршлагатай боловсон хүчнээр бэхжүүлэх, жолооч нарын боловсрол, үйлчилгээний соёлыг дээшлүүлэх талаар ажил зохионо.	-	Сургалт зохион байгуулах тоо	6	7	2025 оны 03 сарын 27-ны өдөр Жендэрийн эрх тэгш байдлын тухай хуулийн хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд "Харилцан хүндэтгэе" аяныг зохион байгуулж Захиргааны албан хаагчид болон үйлчилгээний жолооч, инженер техникийн ажилтан, албан хаагчдад Жендэрийн эрх тэгш байдлын тухай хуулийн талварх мэдлэг мэдээллийг нэмэгдүүлэх зорилгоор онлайнаар тест бөглүүлэн, гарын авлага тараасан. Албан хаагчдын чадамж ахиулах сургалтад 2025 оны 04 дүгээр сарын 24, 25-ны өдрүүдэд Худалдан авах ажиллагааны дэргэдэх А-3-ын сертификат олгох сургалтад Тээвэр зохицуулалтын хэлтсийн дарга, Ерөнхий инженер Ч.Энхсайхан, Ашиглалтын инженер Ц.Оюунцэцэг нар хамрагдсан. Мэдээлэл технологи, архив бичиг хэргийн ажилтан Ц.Дэлгэрмаа Захиргааны бүх албан хаагчдад 2025 оны 09 дүгээр сарын 08-ны өдөр "Монгол бичгээр албан хэрэг хөтлөх нь", "Албан	100%

						хэргийн стандарт" сэдвээр сургалт зохион байгуулсан. Ашиглалтын инженер Ц.Оюунцэцэг ХАБ инженер Ц.Энхжаргал нарыг НЗДТГ-ын Хүний нөөцийн хөгжлийн төвөөс зохион байгуулдаг сургалтуудад тогтмол хамруулсан. Үүнд: ERP системийн хэрэглээ, Цахим орчны боломжийг ашиглан ажлын бүтээмжээ нэмэгдүүлэх нь, Стресс менежмент, зэрэг сургалтуудад хамруулсан байна. Үйлчилгээний жолооч нарт "Төрийн албан хаагчийн ёс зүй", "Хувь хүний соёл, харилцаа, хандлага"-н талаарх танилцуулга пост мэдээлэл байгууллагын цахим сүлжээгээр тогтмол хүргэж ажилласан.	
4.5	Нийслэлийн Төр захиргааны авто бааз УТҮГ-ын дүрмийн 4.5. Авто үйлчилгээнд зөрчил гарахаас урьдчилан сэргийлэх, буруутай үйлдлийг илрүүлж, таслан зогсоох, хариуцлага хүлээлгэх, учирсан хохирлыг арилгуулах, жолооч нарын ангилал дээшлүүлэх, сургах, мэргэшүүлэх, хөдөлмөрийн нөхцөлийг сайжруулах арга хэмжээ авна.		Арга хэмжээ, үйл ажиллагааны хэрэгжилт хувиар	100%	100%	2025 оны жилийн эцсийн байдлаар 6 тээврийн хэрэгсэл осол гаргасан (бусдын буруугаас) бөгөөд учирсан хохирлыг бүрэн барагдуулж, зөрчил гаргасан үйлчилгээний жолооч нарт хариуцлага тооцож ажилласан. Мөн байгууллагын дотоод сүлжээ болон үйлчилгээний жолооч нарт Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг ханган хөдөлгөөнд оролцох тухай мэдээллийг байнга хүргүүлснээр Замын хөдөлгөөний дүрэм зөрчих асуудал байгууллагын хэмжээнд өмнөх онтой харьцуулахад 7%-иар буурсан байна.	100%

	4.6	Нийслэлийн Төр захиргааны авто бааз УТҮГ-ын дүрмийн 4.6. Шатахуун, тослох материал, автомашины сэлбэг, дулаан, цахилгаан, усны үнэ нэмэгдэхэд үйлчилгээний үнэ тарифыг өөрчлөх саналыг Нийслэлийн Засаг даргын Тамгын газар бусад холбогдох газруудтай хамтран боловсруулан Нийслэлийн Засаг даргад танилцуулан, шийдвэрлүүлэн, мөрдөж ажиллана.	-	Үйл ажиллагааны хэрэгжилтийн хувиар	80%	100%	Үйлчилгээний үнэ, тарифыг 2024 оны 01 дүгээр сарын 17-ны өдрийн А/56 дугаар захирамжаар шинэчлэн баталж, 2024 оны 01 сараас эхлэн үйл ажиллагаандаа мөрдөн ажиллаж байна. Тайлант хугацаанд үйлчилгээний үнэ, тарифт өөрчлөлт оруулах шаардлага үүсээгүй болно.	100%
Тав. Төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах хүрээнд: ХХИ Засаглал 42, Хүртээмжтэй байдал 64								
5	5.1	Хариуцсан чиг үүргийн хүрээнд үүргийн шинжилгээ хийж, засаглалын тогтолцоог оновчтой болгох замаар үр ашгийг нэмэгдүүлж, удирдлагын тогтолцоонд реформ хийх ажлыг эхлүүлнэ.	-	Үйл ажиллагааны хэрэгжилтийн хувиар	0%	100%	Нийслэлийн Засаг даргын Тамгын газраас 2025 оны 04 дүгээр сарын 09-ний өдрийн 03/2993 тоот албан бичгийн хүрээнд байгууллагын засаглалын өнөөгийн төлөв байдлыг тодорхойлох дотоод үнэлгээг хийсэн. Тус үнэлгээ нь 3 бүлгийн 7 зарчмын хүрээнд тодорхойлон үнэлгээг www.moontra.com цахим системд байршуулсан үнэлгээний цахим маягтаар бөглөж, тайланг хүргүүлэн ажилласан. Засаглалын төлөв байдлын үнэлгээний зөвлөмжийн дагуу байгууллагын 2024-2028 оны стратеги төлөвлөгөөг боловсруулан батлуулсан.	100%

						Байгууллагын бүтэц, зохион байгуулалтын үр ашгийг нэмэгдүүлэх, албан тушаалын давхардлыг арилгах зорилгоор Нийслэлийн Засаг даргын 2025 оны А/614 дүгээр захирамжаар байгууллагын орон тооны хязгаарт өөрчлөлт оруулалгүй албан тушаалын шилжилт хийж удирдлагын тогтолцоонд реформ хийх ажлыг амжилттай эхлүүлсэн.	
5.2	Техникийн улсын үзлэг оношилгоо, даатгал хамруулна.	25.7 (сая.төг) өөрийн хөрөнгөөр	Үйл ажиллагааны хэрэгжилтийн хувиар	100%	100%	Байгууллагын эзэмшилд бүртгэлтэй 94 тээврийн хэрэгслийн 2025 оны үзлэг оношилгооны төлбөрт 1.9 сая, нийт тээврийн хэрэгслийн албан журмын даатгалд 10.2 сая төгрөгийн даатгалын хураамжуудыг тус тус төвлөрүүлэн ажилласан. 2025 онд тээврийн хэрэгслийн татвар нэмэгдсэнтэй холбоотойгоор тухайн зардлаас хэмнэсэн төсвийн 6.6 сая төгрөгийг тээврийн хэрэгслүүдийн татварын зардал руу шилжүүлсэн.	100%
5.3	Тээврийн хэрэгслүүдийн татвар, хураамжийг хуулийн хугацаанд төлж барагдуулна.	12.5 (сая.төг) өөрийн хөрөнгөөр	Үйл ажиллагааны хэрэгжилтийн хувиар	100%	100%	2025 оны 11 дүгээр сарын байдлаар бүртгэлтэй тээврийн хэрэгслүүдийн албан журмын татварт 19.1 сая төгрөгийн хураамжийг төвлөрүүлэн ажиллаж байна. 2025 онд тээврийн хэрэгслийн албан журмын даатгалын хураамж нэмэгдсэнтэй холбоотой төсөвлөсөн зардал хэтрэлттэй байна.	80%
5.4	MNS ISO 9001:2016-чанарын менежментийн тогтолцооны стандартын нэвтрүүлнэ.	-	Үйл ажиллагааны хэрэгжилтийн хувиар	0	100%	MNS ISO 9001:2016-чанарын менежментийн тогтолцоог байгууллагын үйл ажиллагаанд нэвтрүүлснээр гарч болох эерэг нөлөөллийг албан хаагчдад танилцуулж, 2026 онд уг стандартыг нэвтрүүлэх ажлыг зохион байгуулахаар	100%

							байгууллагын 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгасан.	
5.5	Нийслэлийн Нутгийн захиргааны байгууллагуудын дотоод удирдлагын нэгдсэн системийг ашиглах журам, "UB.ERP"-ийн холбогдох дэд системүүдийн ашиглалтыг бүрэн хариуцаж баяжилтыг тогтмол зохион байгуулна.	-	Үйл ажиллагааны хэрэгжилтийн хувиар	100%	100%		Хяналт шинжилгээ үнэлгээний дэд систем дээр 2025 оны жилийн эцсийн байдлаар нийслэлийн удирдах ажилтны 21 удаагийн шуурхай зөвлөгөөнөөс өгсөн 5 үүрэг даалгаврыг биелэлтийг оруулж ажилласан. Өргөдөл гомдлын дэд системд 2025 оны жилийн эцсийн байдлаар нийт 97 өргөдөл хүсэлт ирснийг программд бүртгэн, өргөдлийг хуулийн хугацаанд 97 өргөдлийг шийдвэрлэсэн байна. 11-11 төв болон 1800-1200 операторт ирсэн 1, 1 гомдлыг хуулийн хугацаанд шийдвэрлэсэн. Өргөдөл, гомдлын программд өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн хариуг журмын дагуу 5 хоногт 78 (80,41%), 10 хоногт 8 (8,25%), 15 хоногт 5 (5,15%), 30 хоногт 5 (5,15%) хугацаа сунгасан 1 (1,03%). Өргөдөл, гомдлын индексээр (PCI) 0,87 буюу "B" үнэлгээтэй байна. 2025 оны жилийн эцсийн байдлаар едөрт нь багтаан шилжүүлээгүй зөрчил 4, едөрт нь багтаан хүлээн аваагүй зөрчил 50, явцын тэмдэглэл хөтлөөгүй 3 хугацаа хэтэрч шийдвэрлэсэн өргөдөл, гомдол байхгүй байна. Edoc системд байгууллагын хэмжээнд нийт 280 албан бичиг ирсэн. Үүнээс Захиргаа хүний нөөцийн хэлтэст 133, Санхүү төлөвлөлтийн хэлтэст 68, Тээвэр зохицуулалтын хэлтэст 79 албан бичиг ирсэн байна. Хариутай албан бичиг 55, хариугүй албан бичиг 225 ирсэн байна.	100%

						Албан бичгийн шийдвэрлэлтийн дундаж 92,76% байна. Байгууллагаас нийт 279 явуулсан. Үүнээс Захиргаа хүний нөөцийн хэлтсээс 98, Сөнхүү, төлөвлөлтийн хэлтсээс 136, Тээвэр зохицуулалтын хэлтсээс 45 албан бичиг явуулсан байна. Дуудлагын автомашин захиалгын системээр 2025.01.01-ний өдрөөс 2025.11.28-ны өдрийг хүртэл нийтдээ 1336 захиалга авсан үүнээс системээр 1036 захиалга, утсаар 152 захиалга авч нийт 1188 дуудлага захиалгыг хүлээн авч ажил үйлчилгээнд гаргасан байна. Захиалагч байгууллагын санаачлагчаар 119, байгууллагын үйл ажиллагаатай холбоотойгоор (үйлчилгээний жолооч, тээврийн хэрэгслийн хүрэлцээ дутмаг байгаа учраас) 29 дуудлага захиалга цуцлагдсан байна.	
5.6	Байгууллагын архивыг хөтлөх хэргийн нэрийн жагсаалтын дагуу бүрдүүлж ажиллах	-	Үйл ажиллагааны хэрэгжилтийн хувиар	100%	100%	Байгууллагын архивт 2025 онд үүссэн цаасан суурьтай байнга хадгалах 19, түр хадгалах 96, 70 жил хадгалах 6 баримт нийт 121 баримтыг байгууллагын архивт актаар хүлээн авч нөхөн бүрдүүлэлт хийсэн.	100%
5.7	Хяналт, мониторингийн тогтолцоог сайжруулах	-	Үйл ажиллагааны хэрэгжилтийн хувиар	0	100%	Хяналт, мониторингийн тогтолцоог сайжруулах зорилгоор байгууллагын 2024-2028 оны стратеги төлөвлөгөөнд KPI үзүүлэлтүүдийг стратегийн зорилтууддаа уялдуулан төлөвлөсөн. Мөн MNS ISO 9001:2016-чанарын менежментийн тогтолцооны стандартыг нэвтрүүлэхээр 2026 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгаж байна. 2025 онд 47 тээврийн хэрэгслийн парк шинэчлэл хийсэнтэй холбогдуулан	100%

						тээврийн хэрэгслийн мониторингийн тогтолцоог сайжруулах зорилгоор тээврийн хэрэгслийн байршил заагч төхөөрөмж буюу GPS төхөөрөмжийг тээврийн хэрэгслүүдэд байршуулах болон түүнийг хянах хяналтын программыг нэвтрүүлэхээр "Би Ти Жи Ти" ХХК-тай гэрээ байгуулан гэрээний дагуу ажиллаж байна.	
5.8	Хариуцсан чиг үүргийн хүрээний албан ёсны болон захиргааны статистикийн мэдээллийг боловсруулах, тайлагнах тогтолцоог хөгжүүлэх ажлыг эхлүүлэх	-	Үйл ажиллагааны хэрэгжилтийн хувиар	0	100%	Байгууллагын хариуцсан чиг үүргийн хүрээнд үүсэх бүх төрлийн албан ёсны болон захиргааны статистикийн мэдээллийг нэг стандартаар, алдаа багатай боловсруулж, тогтмол тайлагнах нэгдсэн тогтолцоог бүрдүүлэх зорилгоор 2026 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд зохион байгуулах арга хэмжээ, биелүүлэх хугацааг тодорхой тусган төлөвлөсөн.	100%
Биелэлтийн дундаж хувь							98.7%

ТАНИЛЦСАН:
НИЙСЛЭЛИЙН ТӨР ЗАХИРГААНЫ
АВТО БААЗ УТУГ-ЫН ДАРГА

ХЯНАСАН:
ЗАХИРГАА ХҮНИЙ НӨӨЦИЙН
ХЭЛТСИЙН ДАРГА

НЭГТГЭСЭН:
МЭДЭЭЛЭЛ ТЕХНОЛОГИ, АРХИВ
БИЧИГ ХЭРГИЙН АЖИЛТАН



Э.БОЛОР-ЭРДЭНЭ

М.БОЛОРМАА

Ц.ДЭЛГЭРМАА